

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

(2022 оны жилийн эцсийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

2022.11.25

Улаанбаатар хот

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага Хэрэгжүүлэх хугацаа	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг), эх үүсвэр	Суурь түвшин	2022 оны зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц, үр дүн, хэрэгжилтийн хувь
					Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	
1	2	3	4	5	6	7	8	9
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО								
3.2. Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.								
3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.	5."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барина.	УУХҮЯ, "ЭҮ" ТӨҮГ, ТӨБЗГ 2020-2024	1,628,400.0 Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт (30% "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ өөрийн хөрөнгө, 70% гадаад/дотоод хөрөнгө	0%	Үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлж, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийнэ. 50%	690,754.0	10,1*5.0 (өссөн дүн)	ТӨБЗГ - ТӨУЗХ Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг 2020 онд боловсруулсан. "Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл"-д Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/103 дугаар тушаалаар байгуулагдсан Шинжээчийн ажлын хэсгийн гаргасан шүүмж дүгнэлтийг 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдөр тус яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Хүнд үйлдвэрийн салбар зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэж, дэмжсэн байна. Зэсийн баяжмалыг хайлуулах, боловсруулах явцад гарах хүхрийн давхар исэл агуулсан хийг

			оруулалт, зээл)					<p>боловсруулж, элементийн хүхэр үйлдвэрлэх туршилт, судалгааны ажлыг технологийн патентыг эзэмшигч БНХАУ-ын ENFI компанитай хамтран гүйцэтгэж байна. Гэрээний санхүүжилтийн нийт дүн 11,245.0 сая төгрөг бөгөөд түүний 90% букуу 10,115.0 сая төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэлтэй байгаа.</p> <p>Үйлдвэрлэлийн туршилтын ажлын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, зохион байгуулалтын оновчтой арга хэмжээ авснаар 2023 оны 06 дугаар сард дуусгах боломжтой гэж үзэж, энэ талаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр ENFI компанид албан бичгээр мэдэгдсэн байна.</p> <p>2022 оны 11 дүгээр сарын 01 өдөр зохион байгуулсан “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын удирдлага, холбогдох мэргэжилтнүүд China ENFI Engineering (ENFI)-ийн Дэд ерөнхийлөгч болон бусад холбогдох төлөөлөл оролцсон цахим хурлаар үйлдвэрлэлийн туршилтын ажлыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. Мөн туршилтын ажлын хугацааг 2023 оны эхний хагас жилд багтаан, боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх боломжтой талаар хэлэлцсэн.</p> <p>Төслийн ажлыг эрчимжүүлэх асуудлаар БНХАУ-ын холбогдох төр, захиргааны байгууллагад хандах, холбогдох дэмжлэг үзүүлэх чиглэлээр УУХҮЯ-нд хүсэлт хүргүүлсэн байна.</p> <p>Хэрэгжилтийн хувь: 30%</p>
6."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд	УУХҮЯ, “ЭҮ” ТӨҮГ, ТӨБЗГ	167,371.0	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	0%	Үйлдвэрийн барилгын ажлыг гүйцэтгэж дуусгана.	83,685.5	745.2 (өссөн дүн)	ТӨБЗГ – ТӨУЗХ Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах (SX-EW) технологиор боловсруулах катодын зэсийн үйлдвэр /Катодын зэсийн үйлдвэр/-ийн ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах

	Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна.	2020-2022	34% "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ өөрийн хөрөнгө, 66% гадаад/дотоод хөрөнгө оруулалт, зээл/		100%		<p>ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Mining short long term" ХХК-тай байгуулсан гэрээний санхүүжилт 30% буюу 745.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа.</p> <p>Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах SX-EW технологиор жилд 10.0 мянган тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар байгуулагдсан Шинжээчийн ажлын хэсгээс гаргасан шүүмж дүгнэлтийг тус яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдөр хэлэлцэж дэмжсэн байна.</p> <p>Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэхээр техникийн даалгавар боловсруулах ажил хийгдэж дууссан бөгөөд ТЭЗҮ, Нарийвчилсан зураг төслийн ажил удааширсан тул 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж байна. Үйлдвэрийн Ерөнхий захирлын өргөтгөсөн зөвлөлийн (2022.10.13-нд) хурлаар тус компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг Техникийн зөвлөлөөр хэлэлцэх, дэмжвэл УУХҮЯ-ын ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх, тэр хүртэл гэрээг сунгаж ажиллах, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг дахин авч хэлэлцэх чиглэл өгөгдсөн. 2022.11.02-ны өдөр Техникийн зөвлөл хуралдаж, ТЭЗҮ-д дахин санал дүгнэлт гаргах шийдвэр гаргаад байна.</p> <p>Катодын зэсийн үйлдвэрийн ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг шуурхайлах, 2023 оноос бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.</p> <p>Хэрэгжилтийн хувь: 30%</p>
3.7.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.							

<p>3.7.8. Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэ зохион байгуулалтаар өргөжүүлэн хэрэгжүүлнэ.</p>	<p>1.Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци байгуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, корпорацийг шинээр байгуулна.</p>	<p>БХБЯ, ТӨБЗГ 2020-2024</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>Үндэсний орон сууцны нэгдсэн корпорацийг шинээр байгуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ.</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>ТӨБЗГ – ТӨУЗХ</p> <p>Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК болон “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийг нийлүүлэх замаар өөрчлөн зохион байгуулж төрийн өмч давамгайлсан (жаран зургаан хувиас доошгүй) “Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай асуудлыг хэлэлцэж, Засгийн газрын хуралдааны 13 дугаар тэмдэглэл гаргасан.</p> <p>“Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци” ХХК байгуулах асуудлыг 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийг татан буулгаж, шинэ байгууллагад нэгтгэх асуудлаар ажлын хэсгийн дүгнэлт гаргахаар болсон боловч өнөөдрийг хүртэл ямар нэгэн шийдвэр гаргаагүй байна.</p> <p>Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцэн шийдвэр гаргасны дараа “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл энэхүү асуудлыг хэлэлцэх, зохих шийдвэр гаргах боломжтой тул удааширч байна.</p> <p>“Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци” байгуулах асуудалтай холбоотойгоор 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Монгол Улсын Хөгжлийн банк, Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК, “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК зэрэг байгууллагуудыг оролцуулан уулзалт зохион байгуулсан. Энэхүү хурлын үеэр Барилга, хот</p>
--	--	--------------------------------------	----------	----------	---	----------	----------	---

								байгуулалтын яамны зүгээс “Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци”-ийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлон танилцуулсан байна. Хэрэгжилтийн хувь: 70%
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО								
4.1.“Цахим Монгол”- төрийн шуурхай үйлчилгээ. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.								
4.1.4. Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ.	5.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож (программ хангамж, техник хангамж, 2 ширхэг сервер), нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбоно.	ТӨБЗГ 2021-2024	1,200.0 Улсын төсөв	Програм-мын болон техник хангамжийг сайжруулах шаардлагатай.	Программ хангамжийг сайжруулах төлөвлөгөө гаргаж, техник хангамжийн төсвийг батлуулан байна.	800.0	-	ТӨБЗГ – ТӨБАХ, МТА, ЗУХ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад 1.2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэн гүйцэтгэхээр тусгагдаж, холбогдох бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны тендерийг зарлан гүйцэтгэгчийг шалгаруулсан байсан. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсантай холбоотой Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад өөрчлөлт орсноор батлагдсан төсөв нь хасагдсан тул гэрээ байгуулах боломжгүй болсон. ТӨБЗГ-аас байгууллагын 2023 оны төсвийн урсгал зардлаар уг зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр зорьж, шаардлагатай 1.2 тэрбум төгрөгийн зардлыг төсвийн төсөлд тусгаж, саналаа Төсвийн Ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн боловч батлагдаагүй байна. Уг төсөл, арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлүүлэх арга хэмжээний хүрээнд Цахим

								хөгжил, харилцаа холбооны яам, Сангийн яаманд тус тус хүсэлт хүргүүлсэн. Хэрэгжилтийн хувь: 90%
4.2.Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.								
4.2.4.Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, удирдлага, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх замаар төрийн өмч үнэгүйдэх асуудлыг таслан зогсооно.	1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чадавхыг бэхжүүлж, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, нөхцөлөөр хангана.	ТӨБЗГ 2021-2024	-	Эрх зүйн орчин сул, бүтэц, орон тоо, төсөв хангалтгүй.	Төрийн болон орон нутгийн өмчийн асуудлыг хариуцсан тохируулагч агентлаг бий болсон байна.	-	-	ТӨБЗГ – ХЭЗХ, ТӨУЗХ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг хэт ерөнхий болон давхцал, хийдэлтэй зохицуулсны улмаас хяналт хэрэгжүүлэхэд хүндрэл учирч, төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, түүнд тавих хяналтыг сулруулж, үр өгөөжгүй захиран зарцуулах үр дагаварт хүргэж байна. Иймээс, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд эрх зүйн орчныг боловсронгуй болгосноор уг асуудлыг шийдвэрлэх үндэслэлтэй гэж үзэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын статусыг шийдвэрлэж, чадавх, үйл ажиллагааны цар хүрээ, чиг үүргийг тодорхой болгох асуудлыг тусгасан. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтран боловсруулсан бөгөөд ЗГХЭГ-аас 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр УИХ-д өргөн барьсан. Хэрэгжилтийн хувь: 90%
	2.Төрийн өмчит болон төрийн өмчийн	ТӨБЗГ 2020-2024	196.0 Улсын төсөв	19 хуулийн этгээд	25 хуулийн этгээдэд хяналт шалгалт	60.0	58.2 (өссөн дүн)	ТӨБЗГ – ТӨХШ Засгийн газрын шийдвэрээр “Цемент шохойн үйлдвэр” ТӨХК, “Дарханы төмөрлөгийн

	<p>оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хяналт шалгалт хийж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулна.</p>			<p>хийсэн байна.</p>		<p>үйлдвэр" ТӨХК, "Эрдэнэс Таван толгой" ТӨХК-д төлөвлөгөөт бус шалгалт хийх болсонтой холбогдуулан ТӨБЗГ-аас хуулиар олгогдсон чиг үүргийн дагуу 2022 онд хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан 45 хуулийн этгээдээс 10 хуулийн этгээдийг хасаж, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан.</p> <p>ТӨБЗГ-аас хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу газрын даргын баталсан удирдамжаар нийт 35 хуулийн этгээдэд баримтын хяналт шалгалт хэрэгжүүлэв.</p> <p>2022 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчит хуулийн этгээдэд хийсэн хяналт шалгалтын тайланг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулсан дүнгээр 6 хуулийн этгээдэд хамаарах нийт 1,180.94 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг баталгаажуулаад байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - "Төв АЗЗА" ТӨХК – 197.6 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2022 оны 226 дугаар тогтоолоор; - "Өвөрхангай АЗЗА" ТӨХК – 242.04 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2022 оны 282 дугаар тогтоолоор. - "Монгол кино нэгтгэл" ТӨҮГ -73.7 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2022 оны 332 дугаар тогтоолоор; - "Талын зам" ТӨХК – 226.2 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2022 оны 333 дугаар тогтоолоор; - "Багануур АЗЗА" ТӨХК - 31.4 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2022 оны 398 дугаар тогтоолоор; - "Эрдэнэсант АЗЗА" ТӨХК - 410.0 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2022 оны 334 дугаар тогтоолоор. <p>Шалгалтын мөрөөр авах 71 арга хэмжээг дээрх тогтоолуудад тусган шалгалтын тайлангийн хамт тухайн компанид хүргүүлсэн.</p> <p>2021 оны эцсээр хийгдсэн "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн хяналт шалгалтын тайланг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулж, илрүүлсэн 1,822.7 сая төгрөгийн</p>
--	--	--	--	----------------------	--	---

								<p>зөрчил, дутагдлыг баталгаажуулж, шалгалтын дүнтэй холбоотой 12 арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар тухайн компанид үүрэг даалгавар өгсөн байна.</p> <p>Хяналт шалгалтын мэдээллийг бүртгэлийн нэгдсэн санд оруулж баяжилт хийсэн.</p> <p>Төрийн өмчийн хяналт шалгалтын ажлаар орон нутагт ажиллах томилолтын зардалд 80.3 сая төгрөгийг зарцуулахаар улсын төсөвт тусгагдсанаас өссөн дүнгээр 58.2 сая төгрөгийн төсвийг зарцуулсан байна.</p> <p>Хэрэгжилтийн хувь: 100%</p>
3.Төсөвт байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийж, төрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлнэ.	ТӨБЗГ 2020-2024	75.0	7 хуулийн этгээд	10 төсөвт байгууллагад шалгалт хийсэн байна.	20.0	2.9	<p>ТӨБЗГ – ТӨХШХ</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 22-02/01 дугаартай шалгалтын удирдамжийн дагуу Гаалийн ерөнхий газрын харьяа 10 салбар нэгжийн эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд системийн хяналт шалгалтыг хэрэгжүүллээ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улаанбаатар хотын Гаалийн газар; 2. Замын-Үүд дэх Гаалийн газар; 3. Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар; 4. Өмнөговь аймаг дахь Гашуун сухайт Гаалийн газар; 5. Өмнөговь аймаг дахь Шивээ хүрэн дэх Гаалийн газар; 6. Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газар; 7. Ховд аймаг дахь Гаалийн газар; 8. Дорноговь аймаг дахь Сайншанд Гаалийн газар; 9. Увс аймаг дахь Гаалийн газар; 10. Сүхбаатар аймаг дахь Бичигт Гаалийн газар зэрэг болно. <p>Хяналт шалгалтын тайланг боловсруулж, нэгтгэх ажил хийгдэж байна.</p>	

								<p>Уг хяналт шалгалтын явцад Гаалийн ерөнхий газрын харьяа 10 салбар нэгжид 2021 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгө оруулалт, их засварын ажлын мэдээллийг цуглуулан, боловсруулалт хийж байна.</p> <p>Дээрх аймгуудад ажиллах томилолтын зардалд 2.9 сая төгрөгийг зарцуулсан байна.</p> <p>2021 онд эхэлж, он дамжин 2 хуулийн этгээдэд хийгдсэн системийн хяналт шалгалтын тайланг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулж, илрүүлсэн 245.94 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг баталгаажуулан шийдвэр гаргасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Халдварт өвчин судлалын үндэсний төв – 19.02 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2022 оны 224 дүгээр тогтоолоор; - Хавдар судлалын үндэсний төв – 226.93 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2022 оны 225 дугаар тогтоолоор. <p>Шалгалтын мөрөөр авах 16 арга хэмжээг дээрх тогтоолд тусгаж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан. Хяналт шалгалтын дүнгээр гарсан тогтоол, тайланг мэдээллийн нэгдсэн санд оруулж, баяжуулалт хийсэн.</p> <p>Хэрэгжилтийн хувь: 100%</p>
<p>4.4. Хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хууль ёсыг бэхжүүлнэ.</p>								
4.4.10. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн	1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн	ХЗДХЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч) 2020-2023	20.0	Хуулийн төслийг боловсруулсан байна. /40.0/	Хуулийн төслийг батлуулсан байна.	-	-	<p>ТӨБЗГ – ХЭЗХ</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтран боловсруулсан бөгөөд ЗГХЭГ-аас 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр УИХ-д өргөн барьсан.</p>

<p>өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.</p>	<p>этгээдийн тухай хуулийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.</p>							<p>УИХ-ын 06 дугаар сарын 10-ны өдрийн нэгдсэн чуулганаар Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх эсэх тухай асуудлыг хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шийдвэрлэж, Эдийн засгийн Байнгын хороонд шилжүүлсэн. УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар тогтоолоор ажлын хэсэг байгуулж, ахлагчаар нь УИХ-ын гишүүн Б.Энхбаярыг томилсон. Хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Дэд ажлын хэсгийг 43 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулж байгаа бөгөөд 2 удаа (2022.09.24, 2022.10.15-ны өдөр) хуралдаад байна. Дэд ажлын хэсгийн хурлаар 2 хуулийн төсөлтэй танилцаж, Ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Б.Энхбаярын баталсан ажил үүргийн хуваарийн дагуу ажлын хэсгийн гишүүд тодорхой чиглэлээр ажиллаж байна. Ажлын хэсэг, Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл оролцож байна.</p> <p>Хэрэгжилтийн хувь: 90%</p>
	<p>2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагалдан гарах дүрэм, журмыг боловсруулж, батална.</p>	<p>ТӨБЗГ 2021-2023</p>	<p>-</p>	<p>Зарим дүрэм, журам батлах эрх хуулиар олгогдоогүй.</p>	<p>Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын асуудлаар 3 журмын төслийг баталж, мөрдүүлсэн байна.</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>ТӨБЗГ – ХЭЗХ</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл одоогоор батлагдаагүй тул дагалдан гарах дүрэм, журам боловсруулж, батлуулах ажил хүлээгдэж байна.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг зохицуулсан хууль тогтоомж, журам, дүрмийг боловсронгуй болгож, холбогдох зохицуулалтыг шинээр мөрдөгдөж буй бусад хууль тогтоомжтой нийцүүлэх ажлуудыг хийж байна.</p> <p>Засгийн газрын 2022 оны “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга</p>

								<p>хэмжээний тухай” 203, 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, ТӨБЗГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/54 дүгээр тушаалаар “Автомашин дуудлагын үйлчилгээний нийтлэг журам, үйлчилгээний тариф, зардлын норм, норматив болон төрийн албан хаагчийн албан ажлын ерөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга хэрэгслийн нийтлэг жишгийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг”-ийг байгуулан ажиллуулж байна.</p> <p>Ажлын хэсгээс дараах ажлыг хийсэн байна:</p> <ul style="list-style-type: none"> - Автомашин дуудлага үйлчилгээний асуудалтай холбоотой “Үйлчилгээний үнэ тариф шинэчлэн батлах тухай” асуудлын танилцуулга, төслийг боловсруулж, санал авахаар Сангийн яаманд хүргүүлж, дэмжсэн хариу авсан; - “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд суудлын автомашин ашиглах нийтлэг журам”-ын төслийг боловсруулж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А-1/1988 дугаартай албан бичгээр хүргүүлсэн; - Төрийн албан хаагчийн албан ажлын ерөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, техник хэрэгслийн нийтлэг жишигт өөрчлөлт оруулах асуудлаар холбогдох судалгаа, мэдээлэл, баримт материал цуглуулах, төрийн байгууллагуудаас санал авах ажлыг хийж байна. <p>Хэрэгжилтийн хувь: 90%</p>
	3.Төрийн өмчит болон	ТӨБЗГ	-	Компанийн	Компанийн засаглалын	-	-	ТӨБЗГ – ТӨУЗХ

	<p>төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд олон улсын нийтлэг шаардлагад нийцсэн засаглалын зарчмыг нэвтрүүлнэ.</p>	<p>2021-2024</p>		<p>засаглалын дундаж үнэлгээ - 53.9 хувь</p>	<p>олон улсын сайн туршлагыг нэвтрүүлсэн байна.</p>		<p>УИХ-ын 2022 оны 16 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолд тусгагдсан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 25 компанийн 34 хүртэлх хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй арилжиж, олон нийтийн хяналтад оруулах, засаглал, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ аван ТӨБЗГ-ын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “Нэмэлт хувьцаа гаргах тухай” 336 дугаар тогтоол гаргаж, зохих бэлтгэлийг хангаж байна. Энэ хүрээнд төрийн өмчит хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захирлуудад IPO хийх бэлтгэл хангахад анхаарах асуудлаар Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “Өлзий энд Ко капитал” Үнэт цаасны компанитай хамтран 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр сургалт, семинар зохион байгуулж, гүйцэтгэх удирдлагуудад хугацаатай үүрэг даалгавар өгөв. Энэ хүрээнд “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨҮГ, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК зэрэг компаниудын удирдлагууд IPO-ийн талаар бэлтгэл ажлын талаарх танилцуулгыг 2022 оны 11 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулсан. Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ийг компанийн хэлбэрт шилжүүлэх талаарх холбогдох бэлтгэлийг яаралтай хангах, Монголын цахилгаан холбоо ХК-ийн IPO гаргах тухай бэлтгэл ажлын болон зах зээлийн нарийвчилсан судалгааны төлөвлөгөөг боловсруулах, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн танилцуулгад холбогдох өөрчлөлтийг оруулж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр дахин танилцуулахаар болов.</p>
--	---	------------------	--	--	---	--	---

							<p>Компанийн засаглалын олон улсын туршлагыг судлах хүрээнд Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөлтэй ТӨБЗГ-т хийсэн уулзалт, Сингапур улсын компанийн засаглалын сайн туршлагыг Монгол Улсад нэвтрүүлэх, тус улсын Темасек холдинг корпорацитай холбох асуудлаар яриа хэлцэл хийсний дагуу тус байгууллагатай цахимаар холбогдох бэлтгэл ажлыг хангах, санал солилцох чиглэлээр ажиллав. БНХАУ, Сингапур улстай санамж бичиг байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна.</p> <p>Төрийн өмчит компанийн хууль, эрх зүйн орчин, өмчлөл, засаглалын бүтцийг сайжруулах, цахим шилжилт хийж компаниудын мэдээллийг цахим платформын хүрээнд олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх талаарх зөвлөмж боловсруулах, туслалцаа үзүүлэх чиглэлээр Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас 2 шатны 5 төрлийн техникийн туслалцааг буцалтгүй тусламжийн хүрээнд авахаар ажиллаж байна. Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Төв Ази, Баруун Европын бүсийн Засаглалыг хариуцсан Дэд захирал, хатагтай Хестер Коутанч, Хөрөнгө оруулалтын зөвлөх хатагтай Лизавета Трахалина нартай 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр хийсэн уулзалт, яриа хэлцлийн дүнд эхний ээлжинд төрийн өмчит хуулийн этгээдүүдийн цахим шилжилтийн хүрээнд нээлттэй мэдээллийн цахим сан бүхий цахим платформ байгуулах асуудалд туслалцаа үзүүлэхээр болсон.</p> <p>Төрийн өмчит 9 компанид хийсэн компанийн засаглалын үнэлгээ дунджаар 69.0 хувь байна.</p> <p>Хэрэгжилтийн хувь: 90%</p>
--	--	--	--	--	--	--	---

	<p>4.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>ТӨБЗГ 2022-2024</p>	<p>-</p>	<p>Хуулийн этгээдэд урт болон дунд хугацааны бизнес /хөгжлийн/ төлөвлөгөө байхгүй.</p>	<p>Хуулийн этгээдийг хөгжүүлэх урт болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөг баталсан байна.</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>ТӨБЗГ – ТӨУЗХ</p> <p>Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар хүлээсэн үүргийн дагуу 2022 онд 45.5 тэрбум төгрөгийн төрийн өмчийн ногдол ашиг, Ирээдүйн өв санд 535.1 тэрбум төгрөгийн хувьцааны ногдол ашгийг тус тус төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж байна. ТӨБЗГ-ын 2022 оны 307 дугаар тогтоолоор тогтоосон хувь хэмжээ, хуваарилалтын дагуу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 44 хуулийн этгээдээс төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж байна. 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар төрийн өмчийн ногдол ашгийн нийт 387.1 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Үүнээс улсын төсөвт төвлөрүүлсэн төрийн өмчийн ногдол ашиг 23.4 тэрбум, Ирээдүйн өв санд төвлөрүүлсэн ногдол ашгийн орлого 363.7 тэрбум болно.</p> <p>Холбогдох хууль тогтоомжийн дагуу 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж, хянуулах, батлуулах асуудлаар төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн гүйцэтгэх захирал нарт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А-1/2046 дугаартай албан бичгээр үүрэг, чиглэл өгөв.</p> <p>ТӨБЗГ-ын даргын 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/67 дугаар тушаалаар төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцэн санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгээр төрийн өмчит 40 хуулийн этгээдийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт,</p>
--	---	----------------------------	----------	--	--	----------	----------	---

								зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 12 дугаар сарын эхний долоо хоногийн хуралдаанд оруулан хэлэлцүүлж батлуулахаар бэлтгэж байна. Хэрэгжилтийн хувь: 90%
	5.Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэлээр хяналт тавина.	ТӨБЗГ 2021-2024	425.0 Улсын төсөв	2016 оны улсын нэгдсэн тооллогын дүнгийн мөрөөр авах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн.	900 хуулийн этгээдтэй байгуулсан "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г дүгнэсэн байна.	25.0	268.᠐ (өссөн дүн)	<p>ТӨБЗГ – ТӨБАХ</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-ний 4.4.1-д төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэл хийх, хяналт тавих тухай асуудал тусгагдсан бөгөөд шаардлагатай нийт 301.0 сая төгрөгийн төсөв 2022 оны улсын төсөвт тусгагдсан. Үүнээс 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар нийт 268.0 сая төгрөгийг тоног төхөөрөмж, программ хангамж, түүний зөвшөөрөл, томилолтын зардал, хэвлэлийн үйл ажиллагааны зардалд зарцуулаад байна. Төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэл 33.0 сая төгрөг байна.</p> <p>Улсын үзлэг, тооллогын мэдээллийн системийн техник болон программ хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд нийт 29.6 сая төгрөгийн төсвийг зарцуулж, бүртгэл, дүн мэдээг нэгтгэх боломжийг бүрдүүлснээр төрийн болон орон нутгийн өмчийн 6813 хуулийн этгээдийн улсын үзлэг, тооллогын дүн мэдээг хянан баталгаажуулах ажлыг хийж дууссан.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг, тооллогын дүнг 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлнэ.</p> <p>Нийслэл болон 21 аймагт байгаа төрийн өмчит нийт 1050 хуулийн этгээдтэй байгуулсан "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2021 оны биелэлтийг дүгнэв. Төрийн өмчийн</p>

								бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэх аргачлал”-ын 4.1-д заасны дагуу Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн дүн, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний талаарх танилцуулга бэлтгэж, 12 дугаар сарын эхний долоо хоногт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын ээлжит хуралдаанд танилцуулж, хэлэлцүүлэхэд бэлэн болгосон. Хэрэгжилтийн хувь: 100%
--	--	--	--	--	--	--	--	--

ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН:

ЗГҮАХХАХТ-нд 2 бодлогын хүрээний 5 тэргүүлэх зорилтод хамаарах 5 зорилтыг хэрэгжүүлэх 12 арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан. Эдгээрээс 11 арга хэмжээний үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар, 1 арга хэмжээний хамтран хэрэгжүүлэгч байгууллагаар үүрэг хүлээсэн байна.

Үнэлгээний дүнгийн товч танилцуулга (2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр):

ЗГҮАХХАХТ-нд тусгагдсан арга хэмжээ (заалт)-ний тоо – 12; Үүнээс: 100 %-ийн хэрэгжилттэй - 3 арга хэмжээ; 90 %-ийн хэрэгжилттэй - 6 арга хэмжээ; 70 %-ийн хэрэгжилттэй - 1 арга хэмжээ; 30 %-ийн хэрэгжилттэй - 2 арга хэмжээ; 0 % - 0. Хэрэгжилтийн дундаж үнэлгээ – **80.8 % (цахим системд 81.7 %-тай) буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”** байна.

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

Нэгтгэн боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВӨРИЙН
БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН

Д.ЦЭРЭНЛХАМ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний
тайлангийн 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЕТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРСЭН ТҮВШИН

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	2022 оны жилийн эцэс		Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
				Хүрэх түвшин	Хүрсэн түвшин			
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО								
4.2.Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.								
106 (1)	Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, захиран зарцуулалтад хийсэн хяналт шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн тоо	Хуулийн этгээдийн тоо	26	35	45	2020 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
107 (2)	Төрийн өмчийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн бууралт	хувь	3 хувь	8 хувь	8 хувь	2020 оны суурь түвшин, Өмнөх жилтэй харьцуулсан хувь	Жилд хоёр удаа	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
108 (3)	Төрийн өмчит компанийн засаглалын дундаж үнэлгээ	хувь	53.9	70.0	69.0	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР